

ХИЛИЙН ДЭГЛЭМИЙН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

IMPLEMENTATION OF BORDER REGIME AGREEMENT



Т.АЗЖАРГАЛ

ХСИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн
Эрх зүйн онолын тэнхимийн багш, докторант, ахлах дэслэгч
AZJARGAL T.

Lecturer, department of law theory, Law and Social Science
Institute, the Law Enforcement University, Senior Lieutenant

Товч утга: Судалгаанаас үзэхэд улс орны зах зээлийн харилцаанд шилжиж эхэлсэн 1990-ээд оноос хойшх хугацаанд улсын хил зөрчигчдийн зорилго, арга ажиллагаа, үйлдэлд зарчмын өөрчлөлт орж, хүний наймаа, хууль бус машины наймаа хийх, эх орны байгалийн баялаг, үслэг ан, үнэт дурсгал, хар өвс түүх, хар тамхи зэргийг хил давуулан хулгайгаар хууль бусаар наймаалах, контрабандын чанартай, зохион байгуулалттай мафи хэлбэрийн үйл ажиллагаа, эрүүгийн хүнд гэмт хэрэг (89-р зүйл хууль бусаар Монгол Улсын хил нэвтрэх, 90-р зүйл Улсын хилийн дэглэм зөрчих) үйлдэгдэж байна. Гэтэл 2007 оны 8 дугаар сарын 9-нд Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт орж эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагаас хилийн тагнуулын ажилтныг хассан нь байдлыг улам ноцтой болгож байна. Ингэснээр хилийн дэглэмийн болон хил дээр гарч буй зөрчлийг практикт ажиллаж буй субъект шалгах эрх хумигдсан юм. Ингэснээр зөвхөн хойшлуулшгүй тохиолдолд хил дээр гарсан зөрчилд эрүүгийн процессын ажиллагаа явуулаад харьяаллын дагуу шилжүүлж эргээд хэргийн хувь заяа хэрхэн шийдэгдсэнийг албан тоотоор зөвхөн тоо баримтаар ирүүлдэг болсон нь хилийн зөрчил үйлдэгчид ял завших, хэргийн илрүүлэлт буурахад нөлөөлж байна. Тиймээс хилийн тагнуулын ажилтан эрүүгийн хэрэг бүртгэлт явуулах эрхээр хангагдах зайлшгүй шаардлага харагдаж байна.

Abstract: According to the previous research purposes, methods and actions of illegal immigrants have been changed during the period since 1990s when Mongolia has transited to market economy and criminal felonies which are mostly connected to human trafficking, illegal sales of automobiles, cars, natural and mineral resources, fur animals, valuable memorial items, herbal plants and drugs to and from abroad, organized contraband cases, mafia and secret groups of illegal trades and criminal cases (to enter to border of Mongolia illegally, indicated in the Article Number 89 of Criminal Law and violence of border rule of Mongolia, indicated in the Article Number 90 of Criminal Law) are developed more day by day. On August 09, 2007 Law of Criminal Procedure has been amended and changed that border emissary officer has been omitted from the authority to conduct criminal procedure and it influenced to the condition oppositely. Due to the above amendment of the Law right of a subject who works at the practical site to inspect order rule violence which arises in border site is closed. This influences to illegal immigrants and violators of border rule not to be penalized and investigation procedure of criminal case is reducing. Therefore there is an inevitable urgent requirement which to provide the emissary officers of border with a right to register cases and conduct investigation activities.

Түлхүүр үгс: Хил, хилийн дэглэм, гэрээ, эрүүгийн процесс, хилийн төлөөлөгч.

Key words: Border, border regime agreement, border regime, criminal procedure, border emissary officer.

Манай улсад сүүлийн таван жилийн дунджаар хилийн дэглэм, хоёр улсын хилийн асуудлаар байгуулсан гэрээгээр өмнөд хилд 437 удаагийн хилийн дэглэмийн зөрчил, хойд хилд 706 удаагийн хилийн дэглэмийн зөрчлийг шийдвэрлэн зохицуулсан байна. Иймээс хилийн асуудлаар байгуулсан олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх арга ажиллагааг төгөлдөржүүлэх, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын гэрээ хэлэлцээр, хилийн дэглэмийн уламжлал шинэчлэл, ОХУ, БНХАУ-ын хил хамгаалалтын зарим асуудалд харьцуулалт хийх, өнөөгийн практик

үйл ажиллагаанд өгөх цаашдын санал, дүгнэлт боловсруулах нь нэн шаардлагатай байна.

Аливаа улсын хил¹ нь хүн төрлөхтний нийгмийн хөгжлийн тодорхой үе шат өөрөөр хэлбэл ангийн тэмцлийн болоод бусад улс орны нутаг дэвсгэрийг эзлэн түрэмгийлэх гэсэн тэмцлийн үр дүнд үүссэн түүхэн үзэгдлийн категори юм.

Иймээс тухайн улс орны хил тогтоогдож хамгаалагдах нь олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр хүлээн зөвшөөрсөн зүй тогтолтой байдаг байна.²

Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Хилийн тухай хууль болон Монгол Улсын Хилийн төрийн бодлогод улсын хил хамгаалалтыг удирдан зохион байгуулах төр засгийн эрх барих дээд байгууллагын эрх үүргийг тусгасан байдаг. Энэ утгаараа улсын хил хамгаалалт нь нутаг дэсгэрийн бүрэн бүтэн байдал улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах улс төрийн, цэргийн, эдийн засгийн, дипломатын болон хамгаалалтын бусад хэлбэрийн диалектик нэгдлийн илэрхийлэл юм.

Улсын нутаг дэвсгэр бүрэн бүтэн байх, улсын хил халдашгүй дархан байх зарчим нь Улс гүрний бүрэн эрхийн зарчмаас нутаг дэвсгэр бүрэн бүтэн, хил хязгаар халдашгүй дархан байх зарчим урган гарч байгаа юм. Энэ нь анх олон улсын эрх зүйн нийтээр зөвшөөрсөн үндсэн зарчим болж НҮБ-ын дүрмээр бататгагдсан. Түүний 2 дугаарзүйлийн 4-т НҮБ-ын бүх гишүүн олон улсын харилцаандаа аливаа улсын нутагдэвсгэрийн бүрэн бүтэн байдлын хувьд хүчээр заналхийлэх юмуу хүч хэрэглэхийг цээрлэхийг заасан. Энэ үүрэг нь НҮБ-ын гишүүдэд хамаардаг боловч тогтоож байгаа журам нь нийтэд холбогдоно гэжцохон заасан.

Хилийн халдашгүй дархан байдлыг хангахын тулд хил залгаа улсуудаас гэрээгээр тогтоосон хилийн тодорхой журмыг хилийн дэглэм гэнэ.³

Улсын хилийн дэглэмийн эрх зүйн үндсийг хуулиар тодорхойлж УИХ эрх олгосоны дагуу Засгийн газар хил залгаа улстай байгуулсан гэрээгээр улсын хилийн дэглэмийг тогтооно.⁴

Хилийн дэглэмийн гэрээ нь хоёр улсын засгийн газар хооронд байгуулагдан хилийн аливаа асуудлыг зохицуулах үүднээс хилийн төлөөлөгч нарын гүйцэтгэх үүрэг, эрх хэмжээг тогтоон өгснөөрөө улсынхилийн шугам зөвхөн тухайн нэг улсын өмчийн тухай асуудал биш гэдгийг тодорхойлсон эрх зүйн акт хэмээн ойлгож болно.

¹ Монгол Улсын Хилийн тухай хуулийн 3 дугаар зүйлд Монгол Улсын хилийг “Монгол Улсын нутаг дэвсгэрийн хязгаарыг газрын гадаргуу, усны мандал дээр хил залгаа улсын нутаг дэвсгэрийн хязгаараас зааглаж, Монгол Улсын олон улсын гэрээгээр тодорхойлж, тогтоосон шугамыг Монгол Улсын хил (цаашид “улсын хил” гэх) гэнэ. Уг шугамаас эгц дээш агаарын, мөн шугамаас эгц доош газрын хэвлийн хил байна.Улсын хил халдашгүй дархан байна” гэж тодорхойлсон байдаг. “Монгол Улсын хил” хэмээх ойлголт нь Монгол Улсын бүрэн эрхийн баталгаа, түүний нутаг дэвсгэрийн хуурай газар, ус, агаар мандал, газрын хэвлийн зах хязгаарыг илэрхийлнэ. Улс гүрний нутаг дэвсгэрийн хязгаарыг бусад улсын нутаг дэвсгэр болон олон улсын эрх зүйн дэглэм бүхий орон зайн хэсгээс зааглах зорилгоор олон улсын гэрээний дагуу хамтран эсхүл бие даан тогтоосон шугамыг улсын хил гэнэ.

² 1962 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Бээжин хотноо БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга Ю.Цэдэнбал, БНХАУ-ын төрийн зөвлөлийн ерөнхий сайд Жоу Энх Лай нар гарын үсэг зурж, гэрээний батламжийг 1963 оны 3 дугаар сарын 25-нд Улаанбаатар хотноо солилцож, улмаар уг гэрээг 1975 оны 10 дугаар сарын 5-нд НҮБ-д бүртгүүлснээр манай улсын өмнөд хил олон улсын хэмжээнд баталгаажсан бөгөөд энэхүү гэрээний түүхэн ач холбогдол нь 1962 оны Монгол Хятадын хилийн гэрээг 1974 оны 9 сарын 11-ний өдөр НҮБ-д бүртгүүлэхээр хүсэлт гаргаж 1975 оны 10 сарын 9-ний өдөр албан ёсоор бүртгүүлсэн. 1962 оны Монгол Хятадын хилийн гэрээнээс үндэслэн Монгол Хятадын хилийн дэглэм, хилийн асуудлыг зохицуулж байх тухай хоёр улсын засгийн газар хоорондын гэрээг байгуулсан явдал юм.

³ М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр “Олон улсын эрх зүй” УБ., 72 дугаар тал

⁴ Монгол Улсын хилийн тухай хууль. УБ 2002 он., 14-р зүйл

Монгол Улсын Хил хамгаалаах байгууллага нь Улсын хил хамгаалалтыг зохион байгуулахдаа хоёр улсын болон олон улсын хэмжээнд дагаж мөрдөх 40 гаруй гэрээ, хэлэлцээр, хууль дүрмийг мөрдлөг болгон хэрэгжүүлдэг бөгөөд эдгээр нь шинэ агуулга, хэлбэрээр байнга хөгжин баяжиж ирсэн юм.

Хилийн дархан байдлыг хангах үүднээс улс гүрэн бүр дотооддоо хууль тогтоомжгаргаж, хөрш оронтой хилийн дэглэмийн гэрээ байгуулдаг. Эдгээр нь хилээр нэвтрэх журам, хилийн бүсэд оршин суух, аливаа ажахуйн үйл ажиллагаа явуулах, хилийн дагуух ус, ой мод зэргийг ашиглах, байгаль орчныг хамгаалах зэрэгтэй холбогдсон дэг журам, арга ажиллагааг тогтоодог.⁵

Монгол Улс нь хилийн асуудлаар БНХАУ болон ОХУ-тай байгуулсан олон улсын гэрээнд үндэслэн найрсагаар хамтран ажиллах үзэл санааны дагуу улсын хилийг хамтран хамгаалах, өнө мөнхөд энх тайван найрсаг харилцааны хил байлгахын төлөө хүчин чармайлт гаргаж ажиллахаа илэрхийлэн хилийн дэглэмийн гэрээг байгуулна.

Монгол-Хятадын хилийн дэглэм, хилийн асуудлыг зохицуулж байх тухай БНМАУ-ын засгийн газар, БНХАУ-ын засгийн газрын хоорондын “Эрээнд 1988 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Бээжин хотноо Монголын бүрэн эрхт төлөөлөгч Д.Ёндон, Хятадын бүрэн эрхт төлөөлөгч Лю-Шу-Цин нар гарын үсэг зуржээ. Үүнээс хойш эцэслэн хилийн дэглэмийн гэрээг 2010 оны 6 сарын 1-ний өдөр шинэчлэн байгуулжээ. Энэхүү гэрээг УИХ 2010 оны 10 сарын 21-ний өдөр соёрхон баталсан.

1980 оны “Монгол-Зөвлөлтийн улсын хилийн дэглэм, хилийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай БНМАУ-ын засгийн газар, ЗСБНОУ-ын засгийн газар хоорондын гэрээ” нь улсын хилийн шугамыг арчлан хамгаалах, хилийн ус, хилийн шугам дээрх барилга байгууламжийг ашиглах, ажил үйлдвэрлэл явуулах, байгаль орчныг хамгаалах, хилийн бүрэн эрхт төлөөлөгчийн эрх үүрэг, төгсгөлийг хэсэг гэсэн 5 бүлэг 49 зүйлтэй гэрээ үйлчилж байсныг цаг үеийн шаардлагаар 2007 онд шинэчилсэн.

Улсын хилийн дэглэмийн зорилго нь хил залгаа улстай байгуулсан гэрээг үндэслэн улсын хилийг тодорхой байлгах, хилийн зөрчлөөс⁶ урьдчилан сэргийлэх, улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа болон мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх, хилийн асуудалтай холбогдсон бусад үйл ажиллагааг зохицуулахад оршино.

Тухайлбал, Монгол - Оросын хилийн дэглэмийн гэрээний нэгдүгээр бүлгийн 2-р зүйлд “эрх бүхий байгууллага” - Монгол Улс, ОХУ-ын хилийн бүрэн эрхт төлөөлөгч, тэдгээрийн орлогчид “хил хамгаалах байгууллага”-д улсын хилийг хууль бусаар өөрчлөх явдал гаргуулахгүй байх, улсын хилийн болон хил орчмын дэглэм, хилийн боомтоор хил нэвтрэх журмыг хувь хүн болон хуулийн этгээдээр сахиулан хангах зорилгоор байгуулсан улсын хилийг хамгаалах үүрэг бүхий салбар, нэгтгэл гэж заажээ. Иймд хилийн тагнуулын алба хаагч, заставын дарга нь хил хамгаалах байгууллагын тусгай салбарын захирагчийн хувьд хилийн төлөөлөгч орлогчийн өмнө өөрийн хариуцсан хэсэг дээрээ улсын хилийн дэглэмийг сахиулах, ингэхдээ хил орчмын дэглэмийн биелэлтэд хяналт тавьж, сахиулах үйл ажиллагааг биечлэн гүйцэтгэгч юм.⁷

⁵ М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр “Олон улсын эрх зүй” УБ., 1999 он, 33 дугаар тал

⁶ Хилийн зөрчил гэдэг нь Монгол Улсын олон улсын гэрээ, Хилийн тухай хууль, тогтоомжийн бусад акт, эрх бүхий байгууллагаас тэдгээртэй нийцүүлэн тогтоосон журам зөрчсөн үйлдлийг хилийн зөрчилд тооцно.

⁷ Монгол-Орос улсын хилийн дэглэмийн тухай Монгол Улс, ОХУ хоорондын гэрээ. УБ., 2007 он

Монгол Улсын 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 26-р зүйлд Хилийн тагнуулын алба Эрүүгийн хуулийн 89 (хууль бусаар Монгол Улсын хил нэвтрэх), 90 (Улсын хилийн дэглэм зөрчих), 175 (эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх) дугаар зүйлд заасан гэмт хэрэгт эрүүгийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулахаар заасан байсан бөгөөд 89-р зүйлийг Тагнуулын байгууллагын мөрдөн байцаагч, Тагнуулын байгууллага өөрсдөө илрүүлсэн Эрүүгийн хуулийн 175 (Эд зүйлийг хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлэх) дугаар зүйлд заасан гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулахаар, 90-р зүйл, 175-р зүйлд цагдаагийн байгууллага харьяаллын дагуу хэрэг бүртгэлт мөрдөн байцаалт явуулахаар 2007 онд орсон нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулжээ.

Улсын хил нь нэг улсын үндэсний аюулгүй байдлын зүйл биш юм. Хөрш залгаа улсын аюулгүй байдал давхар хөндөгдөж байдаг учир олон улсын гэрээгээр тогтоогдсон үүргийг Монгол Улс биелүүлэх ёстой.⁸

Одоогоор хилийн тагнуулын алба, хилийн төлөөлөгч нь захиргааны хариуцлагын тухай хуулийн дагуу захиргааны зөрчилтэй хэрэгт хэрэг бүртгэлийн ажиллагаа явуулж байна.

Тухайлбал, Монгол-Орос улсын хилийн дэглэм, хилийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслалцах гэрээний 28, 29 дүгээр зүйлд:

-Хилийг хууль бусаар боловч санамсаргүй давж баригдсан этгээдийг нөгөө талын зохих албан тушаалтанд аль болох богино хугацаанд буцааж шилжүүлэх ёстой. Иймэрхүү хил зөрчигчийг буцаах журмыг Хилийн бүрэн эрхт төлөөлөгчид тогтооно. Харин тэр этгээдийг хүлээн авахдаа татгалзах эрх аль ч талд байхгүй.⁹

-Хилийг хууль бусаар санаатай нэвтэрч баригдсан этгээдийг барьсан талын албан тушаалтанд шилжүүлнэ. Санаатай хил зөрчсөн этгээд нь баригдсан этгээд хэлэлцэн тохирсон талын өөрийнх нь этгээд байвал, баригдсан этгээд хууль бусаар хил нэвтэрснээс гадна нутаг дэвсгэрт нь орж гэмт хэрэг үйлдсэн байвал нөгөө талдаа шилжүүлэхгүй байж болох бөгөөд санаатайгаар хил зөрчсөн этгээдийг барьсан тал зарим зүйлийг нэмж тодруулах шаардлагатай гэж үзвэл ийнхүү тодруулах ажилд шаардагдах хугацаагаар тэднийг саатуулж болох бөгөөд энэ тухайгаа нөгөө талынхаа Хилийн бүрэн эрхт төлөөлөгчид мэдэгдэнэ гэж заажээ.

Уг гэрээний 13 дугаар зүйлд:

➤ Талууд хил зөрчигчийн хил зөрчсөн шалтгааныг тодруулан хил зөрчсөн этгээд санамсаргүй хил давсан тохиолдолд нөгөө талдаа аль болох түргэн шилжүүлнэ.

➤ Хил орчмын нутаг дэвсгэрт мал, гэрийн тэжээвэр амьтдыг хариулгатай байлгана. Нэг тал нь нөгөө талын мал, гэрийн тэжээвэр амьтан хил давж байгааг илрүүлвэл тэр чигээр нь буцааж гаргана. Мал, гэрийн тэжээвэр амьтан хил давж нутгийн гүн рүү орсон бол богино хугацаанд олох буцааж тушаах арга хэмжээг талууд хэрэгжүүлнэ... гэж заажээ.¹⁰

Улсын хилийн дэглэм, журам зөрчигдсөн үед 1995 оны 4-р сарын 17-

⁸ Монгол Улсын Үндсэн хуулийн 10-р зүйлийн 3-т "Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогч дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ."

⁹ Монгол-Орос улсын хилийн дэглэмийн тухай Монгол Улс, ОХУ хоорондын гэрээ. УБ., 2007 он

¹⁰ Монгол-Орос улсын хилийн дэглэмийн тухай Монгол Улс, ОХУ хоорондын гэрээ. УБ., 2007 он

ны өдөр батлагдсан өөрчлөлтийг баримтлана.Үүнд:

19-р зүйлд: Улсын хилийн дэглэм, журам зөрчих


1. Улсын хилийн дэглэм зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүйгээр бол хууль бусаар олсон орлого буюу эд зүйлийг хурааж 5000-40.000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

2. Улсын хил арчлан хамгаалах, хилийн ус болон шугам огтлон гарсан зам, холбооны байгууламж ашиглах, хил орчмын нутагт ан агнах, ажил үйлдвэрлэл явуулах журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй бол 3000-40.000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна


3. Улсын хилийн бүс, зурваст болон хилийн гарц, боомтод тогтоосон журам зөрчвөл 2500-25000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна гэжээ.

Монгол Улсын хойд хилд гарсан зөрлийг тоймлон үзвэл:

Зөрчлүүдийн эзлэх хувийг харьцуулвал: Х ойд хилд 2002-2006 онд гарсан нийт



зөрчлийн 38.3 хувийг хил дамнан малын хулгай, 24.2 хувийг улсын хилээр хууль бусаар сум галт хэрэгсэл, эм, эмийн зүйл түүхий эд зэрэг эд зүйлс нэвтрүүлсэн зөрчил, 15.6 хувийг боомт газраар хүчин төгөлдөр бус бичиг баримтаар хил зөрчихийг завдсан үйлдэл, 5.6 хувийг бэлчээрээр мал давах, 12.2 хувийг хил зөрчин ан хийх байгалийн баялаг түүх зэрэг илэрхий аж ахуйн зорилгоор хил зөрчсөн үйлдэл, 2.3 хувийг хурдан удмын морь хилээр гаргах зөрчил, 1.8 хувийг хар тамхи мансууруулах бодис хилээр нэвтрүүлэхийг оролдох, хар тамхины ургамал түүх зэрэг зөрчлүүд тустус эзэлж байна.



Хойд хилд гарсан зөрчлүүдийг өмнөх жилүүдтэй нь харьцуулвал 2001 онд 33.5 хувь, 2002 онд 3.6 хувь, 2003 онд 35.9 хувь, 2004 онд 12.1 хувь, 2005 онд

15.5 хувиар тустусэссөн байна.¹¹

Хойд хилд сүүлийн таван жилд (2006-2011 онд) гарсан хилийн дэглэмийн зөрчлийн судалгаа:

- 2006 онд 171 удаагийн 374 хүн
- 2007 онд 151 удаагийн 305 хүн
- 2008 онд 114 удаагийн 219 хүн
- 2009 онд 138 удаагийн 265 хүн
- 2010 онд 165 удаагийн 309 хүн
- 2011 онд 138 удаагийн 272 хүн¹²



Монгол-Оросын хилд дээрх хугацаанд гарсан зөрчлүүдийн хэлбэр нь: Оросын талаас:

- Хил давж мал хулгайлах;
- Манай иргэдтэй тохиролцон хил дээр хууль бус наймаа хийх;
- Хил давсан малаа авах;
- Ан хийх, загас барих; ○ Хил давсан малаа авах;
- ○ Гэмт хэрэгтнүүд хил давж оргон зайлах.

Зорилго, шинж байдлын хувьд:

○ -Мал хулгайлах, хууль бус наймаа хийх зэрэг шунахайн сэдэлтэй, эдийн засгийн зорилго агуулгатай зөрчлүүд зонхилж байгаа бөгөөд цаашид ч өсөх хандлагатай байна.

-Ан хийх загас барих, алдсан малаа авах зэрэг ахуйн шинжтэй амжиргааны зорилготой зөрчлүүдээс гадна хар тамхи, мансууруулах бодисын наймааны тусгайзорилготой, улс дамжсан сүлжээ бүхий ноцтой шинжтэй хилийн зөрчил гарсан нь анхаарал татаж байна.

Шалган нэвтрүүлэх боомтуудаар гарсан хилийн зөрчлүүдийн хэлбэр, агуулга, онцлог:

Шалган нэвтрүүлэх боомтуудаар 2002-2006 онд нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгслийн тоог өмнөх 5 жилтэй (1997-2001) харьцуулбал тээврийн хэрэгслийн тоо 53.7 хувиар, зорчигчдын тоо 34.2 хувиар өссөн байна.

Шалган нэвтрүүлэх боомтуудын 2002-2006 онд 2200 хил зөрчигч

¹¹ Хил хамгаалах ерөнхий газар. Нууцын архив

¹² Хил хамгаалах ерөнхий газар. Хил судлалын сектер., УБ 2012 он

саатуулагдсан нь Монгол Улсын хилд дээрх хугацаанд гарсан нийт хилийн зөрчлийн 34.2 хувийг эзэлж байна.

Сүүлийн 5 жилд шалган нэвтрүүлэх боомтоор дотоодоос 495, гадаадаас 1705 хил зөрчигч саатуулагдсан нь өмнөх 5 жилээс (1997-2001) дотоодоос хил зөрчигчдийн тоо 21.3 хувиар буурч, гадаадаас хил зөрчигчдийн тоо 2.6 дахин өссөн байна. (Хавсралт №6, №7)

2002-2006 онуудад ШНБ-уудаар саатуулагдсан хил зөрчигчдийн тоог өмнөх онуудтай нь харьцуулвал гадаадаас хил зөрчин саатуулагдсан хүний тоо 2003 онд 19.9 хувиар өсөж, 2004 онд 4.5 хувиар, 2005 онд 29.2 хувиар, 2006 онд 9.8 хувиар тус тус буурчээ.

Дотоодоос хил зөрчин саатуулагдсан хүний тоо 2003 онд 13.7 хувиар буурч, 2004 онд 1.9 хувь, 2005 онд 3.7 хувиар өсөж, 2006 онд 9.8 хувиар буурсан байна.

Шалган нэвтрүүлэх боомтуудаар гарч буй зөрчлүүд нь хэлбэрийн хувьд:

-Хүчин төгөлдөр бус хуурамч бичиг баримтаар хил нэвтрэхийг оролдох;
-Хориглосон ба хязгаарласан эд зүйлсийг улсын хилээр нэвтрүүлэхийг завдах зэрэг үндсэн хэлбэртэй байгаагаас гадна хүчин төгөлдөр бус хуурамч бичиг баримтын зөрчил нь:

- Баримт бичгийг бүтнээр нь дууриалган үйлдсэн;
- Баримт бичгийн зургийг сольсон;
- Паспорт, визны тамгыг хуурамчаар үйлдсэн;
- Гарын үсгийг дууриалган зурахыг оролдсон буюу зурсан;
- Баримт бичгийн хуудас нэмсэн, дутаасан, сольсон;
- Баримт бичгийн бичиглэлийг имийн аргаар цэвэрлэж нөхөн бичсэн

засварласан, арилгасан;


• Бусдын алдаж үрэгдүүлсэн хүчингүй болсон баримт бичгийг ашигласан зэрэг хэлбэрүүд зонхилж байна.

Дээрх хугацаанд гарсан зөрчлүүдийг орон зай, чиглэлээр судлахад:

-Нийт зөрчлийн 45.2 хувь нь Замын-Үүд-Эрээний чиглэлийн шалган нэвтрүүлэх боомтоор (ШНБ), 38.5 хувь нь Сүхбаатар-Наушикийн чиглэлийн ШНБ-оор, 16.3 хувь Буянт-Ухаа, Эрэнцав зэрэг бусад боомтуудаар гарчээ.



Дээрх зөрчлүүдийг өмнөх 5 жилтэй (1997-2001) харьцуулахад Замын-Үүд-Эрээний чиглэлээр гарсан хилийн зөрчил 10.2 хувь, Сүхбаатар-Наушикийн чиглэлээр гарсан зөрчил 8.8 хувь, бусад боомтуудаар гарсан зөрчил 3.5-4.2 хувиар тус тус өссөн байна.



2002-2006 онд гарсан дээрх хэлбэрийн зөрчлийг өмнөх онуудтай нь харьцуулвал 2003 онд 27.0 хувиар буурч, 2004 онд 20.0 хувиар, 2005 онд 5.2 хувиар, 2006 онд 21,8 хувиар тус тус өссөн байна.

Монгол Улсын урд хилд гарсан зөрчлийг тоймлон үзвэл:

Монгол Хятадын хилийн дэглэм, хилийн асуудлыг зохицуулж байх, хилийн төлөөлөгчдийн харилцах хилийн хэсэг, хил нэвтрэх чиглэл, уулзалтын цэг болон хилийн ажилтнуудын хил нэвтрэх үнэмлэх, хил зөрчигч, мал, гэрийн тэжээвэр амьтдыг хүлээлцэх, баримт бичгийн загвар, хилийн тэмдгийг засварласан, сэргээн босгосон протоколын загвар зэргийг тодорхой заасан байдаг.

Гэтэл өнөөдөр Монгол Улсын хил, хилийн бүс нутгуудаар олон тооны санаандгүй болон санаатай, гэмт хэргийн шинж чанар бүхий үйлдлүүд олноор гарч, гэмт хэргийн шинж чанар нь өөрчлөгдөж улмаар хамрах хүрээ нь тэлж

өсөх хандлагатай болоод байна.

Энэ нь гэмт хэргийг үйлдэгсэд, хил зөрчигчдийн арга, заль мэх нарийсаж тэдгээрийн хамрах хүрээ нь өргөсөн улмаар олон улсыг хамарсан шинж чанар бүхий үйл ажиллагаа болон тэлж байгаатай холбоотой гэж үзэж байна.


Монгол Улсын Засгийн газраас хөрш зэргэлдээ хоёр улсын засгийн газартай байгуулсан хилийн дэглэмийн гэрээнд хилийн төлөөлөгчдийн хариуцаж шийдвэрлэх хилийн асуудлын эрх зүйн хэм хэмжээг тодорхойлсон байдаг бөгөөд өнөөдөр өмнөд хилд хилийн долоон төлөөлөгч үйл ажиллагаагаа явуулж байна.

Хилийн цагийн байдал түүнд хийсэн дүгнэлт:


Хилийн зөрчилд хамаарч буй хүмүүсийн тоо, тэдний нас хүйс ажил мэргэжлийн болон бусад онцлогийн хувьд:

1. Ганцаара
2. Бөөнөөр (олныг хамарсан үймээн гэх мэт гарсан үед)
3. Мал хулгайлах
4. Хил давсан малаа авах
5. Хууль бусаар ан хийх
6. Загас барих
7. Авто машин хил давуулан худалдах
8. Конторбанд гэж хийгдэж байна.

Эдгээрийг задалж үзвэл Хятад Монголын (гадаадаас) хил дээр голлон гарч буй зөрчил:



Монголын талаас хил зөрчигчдийн зорилго



2002-2007 онд Монгол Хятадын хил зөрчсөн судалгаагаар: Монголын талаас:


- о•Хил давсан нийт 15251 мал хил давсан бол үүнээс:
- оУулзалтаар авсан 6741
- оБуцаж ирсэн 4487
- оНийтдээ 78208 малын 72643 толгой малыг гэрээний дагуу шийдвэрлэсэн байна.

2006 онд 22099 толгой мал хил давсны:

- о2072 толгой мал Хятадын талаас
- о1155 нь Монголын талаас хил давснаас
- о1998 эхний хагасжилтэйхарьцуулбал:
- о2072 толгой мал Хятадын талаас
- о1796 толгой мал Монголын талаас хил давсан байна.

оЭндээс үзвэл хариуллаагүй малын тоо Хятадын талд багасаж манай талд өссөн харагдаж байна.

Монгол Улсаар дамжин гуравдагч улс руу гарах иргэдийн тоо:




-ээр өссөн харагдаж байна.

Хятадын хилийн хэсэгт 2005-2007 онд гарсан хилийн зөрчлийг харьцуулж үзвэл 65,9 хувиар хилийн зөрчил нэмэгдэж, 58,5 хувиар малын тоо буурсан байна.

Өмнөд хилд сүүлийн таван жилд гарсан хилийн дэглэмийн зөрчлийн судалгаа:

- o 2006 онд 114 удаагийн 787 хүн
- o 2007 онд 193 удаагийн 681 хүн
- o 2008 онд 99 удаагийн 277 хүн
- o 2009 онд 64 удаагийн 152 хүн
- o 2010 онд 49 удаагийн 91 хүн
- o 2011 онд 32 удаагийн 59 хүн

Үүнээс харахад сүүлийн таван жилд (2006-2011 онд) гарсан хилийн дэглэмийн зөрчлийг өмнөх жилүүдтэй харьцуулахад буурч байгаа харагдаж байна.



Дүгнэлт

Хилийн аюулгүй байдлыг хангах үндсэн нэг нөхцөл нь Монгол Улсын хөрш залгаа хоёр улстай байгуулсан хилийн дэглэмийн гэрээний хэрэгжилт, түүнийг мөрдүүлэх арга аргачлал юм.

Санал

1. Судалгаанаас үзэхэд улс орны зах зээлийн харилцаанд шилжиж эхэлсэн 1990-ээд оноос хойшх хугацаанд улсын хил зөрчигчдийн зорилго, арга ажиллагаа, үйлдэлд зарчмын өөрчлөлт орж, хүний наймаа, хууль бус машины наймаа хийх, эх орны байгалийн баялаг, үслэг ан, үнэт дурсгал, хар өвс түүх, хар тамхи зэргийг хил давуулан хулгайгаар хууль бусаар наймаалах, контрабандын чанартай, зохион байгуулалттай мафи хэлбэрийн үйл ажиллагаа, эрүүгийн хүнд гэмт хэрэг (89-р зүйл хууль бусаар Монгол Улсын хил нэвтрэх, 90-р зүйл Улсын хилийн дэглэм зөрчих) үйлдэгдэж байна. Гэтэл 2007 оны 8 дугаар сарын 9-нд Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт орж эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагаас хилийн тагнуулын ажилтныг хассан нь байдлыг улам ноцтой болгож байна. Ингэснээр хилийн дэглэмийн болон хил дээр гарч буй зөрчлийг практикт ажиллаж буй субъект шалгах эрх хумигдсан юм. Ингэснээр зөвхөн хойшлуулшгүй тохиолдолд хил дээр гарсан зөрчилд эрүүгийн процессын ажиллагаа явуулаад харьяаллын дагуу шилжүүлж эргээд хэргийн хувь заяа хэрхэн шийдэгдсэнийг албан тоотоор зөвхөн тоо баримтаар ирүүлдэг болсон нь хилийн зөрчил үйлдэгчид ял завших,

хэргийн илрүүлэлт буурахад нөлөөлж байна. Тиймээс хилийн тагнуулын ажилтан эрүүгийн хэрэг бүртгэлт явуулах эрхээр хангагдах зайлшгүй шаардлага харагдаж байна.

2. Практикт ажиллах, ажиллаж буй субъектүүдийн олон улсын эрх зүйн шинжлэх ухааны үүднээс хилийн дэглэмийн зөрчлийг хянан шийдвэрлэх холбогдох хууль тогтоомж болоод Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хилийн дэглэмийн гэрээний зүйл заалтыг хэрэглэх практик мэдлэг чадвар дутагдалтай байгаа нь ажиглагдаж байна. Иймээс олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх практик мэдлэг, чадвар, дадлага суулгах хичээл шинээр оруулах хэрэгцээ шаардлага байна.

3. Иймд хилийн дэглэмийн гэрээний зөрчлийг хянан шийдвэрлэх асуудал учир дутагдалтай байна. Учир нь хил дээр үүрэг гүйцэтгэж буй субъект (Заставын дарга, хилийн төлөөлөгч) нь захиргааны арга хэмжээ л авах эрхтэй. Захиргааны хариуцлагын тухай хуульд зааснаар хэдхэн төгрөгөөр торгоод л өнгөрч байна. Мөн захиргааны зөрчлийг давтан үйлдсэн тохиолдолд харгалзан үзэх хөшүүрэг байдаггүй зэрэгтэй холбоотой байна.

Эх сурвалжийн жагсаалт.

Дотоодын хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль УБ хот 1992 он
2. Монгол Улсын хилийн тухай хууль УБ хот 2002 он
3. Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого УБ хот 2002 он
4. Монгол Улсын эрүүгийн хууль УБ хот 2002 он
5. Монгол Улсын захиргааны хариуцлагын тухай хууль УБ хот 1994 он
6. Олон улсын гэрээний тухай Монгол Улсын хууль УБ хот 1993 он
7. Монгол Улсын хил хамгаалалтанд холбогдох тогтоол шийдвэр (1921-1944) УБ хот 1995 он
8. Монгол Улсын Их Хурлын 2002 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 20 дугаар тогтоол. УБ хот 2002 он
9. Монгол Улсын хил хамгаалалтын дүрэм УБ хот 1994 он
10. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал УБ., 2010 он
11. Монгол Улсын хилийг хамтран шалгахад баримталсан бодлого чиглэл, УБ 2006 он
- Олон улсын гэрээ, конвенц
1. "Нэгдсэн үндэсний байгууллагын (НҮБ) дүрвэгсдийн асуудал эрхэлсэн Дээд Комиссаратын газрын дүрэм" 1999 он
2. "Дүрвэгсдийн талаарх олон улсын бага хурлын материал" (Англи хэлээр) Бээжин хот, 1988 оны 9 дүгээр сар
3. Орос-Хятадын гэрээ, хэлэлцээрүүдийн эмхтгэл" (Нэгдүгээр хэсэг) 1689-1949 он
4. "Орос-Хятадын гэрээ, хэлэлцээрүүдийн эмхтгэл" (Хоёрдугаар хэсэг) 1949-2003 он
5. Монгол Оросын хил зөрчигчийг хэрхэх талаар Монгол-Зөвлөлтийн улсын хилийн дэглэм, хилийн асуудлаар хамтран ажиллах харилцан туслах тухай гэрээ.
6. Монгол-Орос улсын хилийн дэглэмийн тухай Монгол Улс, ОХУ хоорондын гэрээ. УБ., 2007 он
7. Монгол хятадын дэглэмийн тухай Монгол Улсын засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын гэрээ
- Хилийн асуудлаарх Засгийн газар хоорондын протоколууд
1. ГХЯ, Архив, 2005 оны 11 сарын 28-ны өдрийн хилийн дэглэмийн протокол. УБ хот 2005 он
2. Монгол Улсын гэрээ хэлэлцээр протоколууд тусгай жагсаалт
3. Монгол Улс БНХАУ-ын хоорондын улсын хилийн шугамыг шалгах хамтарсан комиссын Монголын хэсэг (эмхэтгэл) УБ хот 2002 он
- Ном, сурах бичиг
1. Д. Базарсад. "Улсын хилийн албаны эрх зүйн асуудлууд" УБ хот 1995 он
2. Н.Дэмчиг "Хилийн эрх зүй" УБ хот 2004 он
3. О.Хосбаяр, М.Дүгэрсүрэн "Олон улсын эрх зүй", УБ хот 2008 он

4. Д.Базарсад. "Цэргийн номлол хилийн цэрэг" УБ хот 1996 он
5. Ш. Бадамдорж "Терроризм түүнээс сэргийлэх нь" УБ хот 2003 он
6. Ч.Найдансүрэн, Д.Содномгомбо "Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, түүний хангах зарим асуудал. УБ., 2000 он
7. "Батлан хамгаалахын цагаан ном" УБ хот 2001 он
8. Б.Цэдэн-Иш. "БНМАУ-ын хил хязгаар бүрэлдэж тогтсон түүхээс". Тэргүүн дэвтэр. (БНМАУ-ын өмнө хил). УБ хот 1984 он
9. Б.Цэдэн-Иш "БНМАУ-ын хил хязгаар бүрэлдэж тогтсон түүхэн сурвалж баримт бичгүүдийн эмхэтгэл" УБ хот 1990 он
10. Б. Цэдэн-Иш "Монгол Улсын хил хязгаар бүрэлдэн тогтсон түүхээс" УБ хот 1993 он
11. Б. Цэдэн-Иш "Монгол Улсын хил хязгаар бүрэлдэн тогтсон түүхээс" УБ хот 2003 он
12. Ю. Цэдэнбал "БНМАУ-ын халдашгүй дархан" УБ хот 1983 он
13. С. Тогоохүү "Овоотын цэнхэр хязгаарт" УБ хот 1998 он
14. "Хилийн албаны мэдээлэл" УБ хот 1998 он
15. "БНМАУ-ын хилийн төлөөлөгчдийн ажиллагаа" (гарын авлага) УБ хот 1989 он
16. Б.Даш-Ёндон "Платон захидлууд" УБ хот 1998 он
17. "Хил хамгаалалтын түүхэн сургамж" УБ хот 1996 он
18. Ш.Арвай "Монгол Улсын хил хамгаалалтанд үзүүлэх хүчин зүйлийн нөлөөлөл цаашдын төлөв" (Дорноговь аймаг) УБ хот 2000 он
19. "Эгэл хилчдийн ээдрээт замын сургамж" УБ хот 1998 он
20. П.Баттогтох. "Бүс нутаг дахь терроризмын аюул" УБ хот 2003 он
21. Л.Эрдэнэбаяр. "Мансуурал судлалын үндэс" УБ хот 2001 он
22. В.Жавхланцогт "Контрабанд" УБ хот 2007 он
23. Т.Муратхан, Ц.Ганболд, М.Лхагвасүрэн "Монгол Улсын хилийн төлөөлөгч" УБ хот 2000 он
24. Д.Дашдэлэг "Хилийн асуудлууд" 2008 он
25. Ц.Ганболд "Монгол Оросын хилийн дэглэмийн гэрээний заалтуудыг боловсронгуй болгох нь" (Магистрын ажил)
26. "Монгол Улстай хил залгаа, БНХАУ-ын аймаг хошуудын талаарх товч лавлагаа" (Хилийн тагнуулын газар) УБ хот 2010 он
27. "Монгол Улстай хил залгаа ОХУ-ын районуудын талаарх товч лавлагаа" (Хилийн тагнуулын газар) УБ хот 2010 он
28. М.С.Капица, орчуулсан С.Лочин, П.Шагдар, "БНХАУ: гучин жилд гурван бодлого", УБ, 1984 он
29. Б.Балдоо, С.Дамдинсүрэн, Л.Хайсандай, "Монголын тусгаар тогтнол ба Орос, Хятадын хүчин зүйл", УБ, 1999 он
30. Хятад хэлнээс орчуулсан Г.Гунгаа, "Хятад-Оросын харилцааны түүхэн дэх Монгол Улс", УБ, 1995
31. О.Б.Борисов, Б.Т.Колосков, Зовлөлт-Хятадын харилцаа, УБ, 1979 он
32. БНХАУ-ын гадаад бодлого ба олон улсын харилцаа: 1949-1963, 1 боть, УБ, 1979 он
33. Түүхийн асуудлууд, УБ хот 1969 он
34. Советско-Китайские отношения, 1917-1957: Сборник документов, 1979 он.
35. Хятад дахь хэрэгявдлынтухайд (1963-1973), УБ, 1974
36. Хятадын асуудлын үндсэн байдал 1965-1975, УБ, 1976
- Гадаад хэл дээрхи сурах бичиг бусад ном хэвлэл
1. Oppenheim's International law Ninth Edition, Volume I, Part 2, 1992
2. Werner Levi "Contemporary International law", 1991
3. Mohammed Bedjaoui /general editor/ International law: Achievements and Prospects, Chapters 3, 5, 19, 22
4. Г.И.Тункин и др. Международное право, Москва., 1994
5. Ю.М.Клосов, В.И.Кузнецов. Международное право, Москва., 1994
- Ашигласан вэб сайд
1. <http://bpo.gov.mn>
2. <http://wikipedia.org/com>